



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

26/19 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 9/27

Мандалговь

Г Бичил уурхай эрхлэгчдээс
жонш худалдан авах аж ахуйн нэгж
сонгох тухай

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 70 дугаар тогтоолоор баталсан
“Бичил уурхайн үйл ажиллагааг зохицуулах журам”-ын 5.1 дэх заалт, “Ажлын хэсэг
томилох тухай” аймгийн Засаг даргын 2018.09.05-ны А/369 дугаар захирамжийн 2
дахь заалт, уг захирамжаар томилогдсон ажлын хэсгийн 2018 оны 12 дугаар сарын
25-ны өдрийн хуралдааны тэмдэглэлийг дугаар зүйлийг тус тус үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Гурван сайхан сумын бичил уурхай эрхлэгчдээс жонш худалдан авах аж
ахуйн нэгжээр “Хан Хас трейд” ХХК, “Вастресорсиз” ХХК-уудыг сонгон шалгаруулж
ажиллуулсугай.

Хоёр. Сумын Засаг дарга, худалдан авалт хийхээр сонгогдсон аж ахуйн нэгж,
бичил уурхай эрхлэгчдийн хооронд гурвалсан гэрээ байгуулж ажиллахыг
Гурван сайхан сумын Засаг дарга (Л.Өлзийбат), бичил уурхай эрхлэгч нөхөрлөлийн
ахлагч, аж ахуйн нэгжийн захирлуудад тус тус үүрэг болгосугай.

Гурав. Бичил уурхайн болон худалдан авалтын үйл ажиллагаа хууль
тогтоомжийн дагуу явагдаж байгаад байнгын хяналт тавьж ажиллахыг аймгийн
Мэргэжлийн Хяналтын Газар (Ш.Төрбат), Гурван сайхан сумын Засаг дарга
(Л.Өлзийбат), холбогдох хууль, хяналт, мэргэжлийн байгууллагуудын дарга нарт
үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

О БАТ-ЭРДЭНЭ

488010066